

Кейсийн шинжилгээ: Ла Либертадын Хөдөлмөрлөх эрхийг хамгаалах хөтөлбөр (Перу Улс)



Плаза де Армас, Тружилло, Ла Либертад

Перу Улсын Хөдөлмөр, ажил эрхлэлтийг дэмжих яам:

Перу Улсын Хөдөлмөр, ажил эрхлэлтийг дэмжих яам нь хөдөлмөрлөхөд таатай нөхцөлтэй, үр өгөөжтэй ажлын байраар хангах, ард иргэдэд хөдөлмөрлөх үндсэн эрхээ бүрэн эдлэх боломж олгох, мөн нийгмийн эмзэг бүлгийн эрхийг хамгаалах, тэдний эрхийг зөрчиж буй аливаа асуудлыг зөвлөлдөн шийдвэрлэх замаар эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх зорилготой.

Тус яам ажлын байр, хөдөлмөрийн нөхцөлд тавигдах зохистой шаардлагыг боловсруулан гаргаж мөрдүүлж, хянан шалгаж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжихийн зэрэгцээ тухайн салбарт төрийн бодлогын хэрэгжилтийг хангах үүрэг хүлээдэг.

Мөн эдийн засгийг тогтвортой, үр өгөөжтэй хөгжүүлэх бодлогын дагуу зохистой ажлын байр бий болгон хөгжүүлэхэд хувь нэмэр оруулахын тулд мэдээлэл, зөвлөгөө өгөх замаар албан ёсны хөдөлмөр эрхлэлтийг дэмждэг байна.

Улс орны хөдөлмөрийн зах зээлийн бодит эрэлт, эдийн засгийн хөгжилд нийцүүлэн хөдөлмөрийн насны хүн амын (тэр дундаа залуучууд болон бусад эмзэг бүлгийн хүн амыг чухалчлан үзэж) ажилд орох боломжийг нэмэгдүүлэхийн тулд ажил хийхэд шаардагдах үр чадварыг сайжруулах ажил хийдэг.

Яам ажлын бүтээмж, зохистой ажил эрхлэлтийн урьдач нөхцөл болдог хөдөлмөрийн гурван талт хэлэлцээрт хүрэх үр ашигтай арга хэрэгсэл хэмээн олон нийттэй зөвлөлдөх уулзалт, хэлэлцүүлгийг хөхиүлэн дэмждэг. Ингэснээр улс орны тогтвортой хөгжлийн үндэс суурийг бүрдүүлэхийг зорьдог.

Ла Либертад бүс нутаг:

Бүгд Найрамдах Перу Улс нь хоёрдмол тогтолцоотой холбооны улс юм. Засаг захиргааны нэгжийн хувьд бүс нутаг, муж, дүүрэг, суурингуудад хуваагддаг. Нийт 25 бүс нутаг байдаг бөгөөд бүс нутаг болгон төрийн удирдлагын бүхий л эрхийг бие даан хэрэгжүүлдэг Засгийн газрыг сонгон байгуулдаг. Харин батлан хамгаалах, гадаад харилцааны асуудлыг улсын хэмжээнд нэгдмэл байдлаар удирддаг. Бүс нутаг бүр бүсийн удирдах байгууллага хэмээн нэрлэгддэг Бүсийн Хөдөлмөр, ажил эрхлэлтийг дэмжих яамтай.

Ла Либертад бүс нутаг нь улсын баруун хойд хэсэгт Номхон далайн эрэгт оршдог. 2017 оны байдлаар 1.9 сая хүн амтай. Бүс нутгийн Ла Либертад хэмээх нэр нь Испани хэлний “эрх чөлөө” гэсэн утгатай үг бөгөөд 1820 онд Испаниас тусгаар тогтнохын төлөө тулалдаж, тунхаглаж байсан Захирагч Тружиллогийн гэгээн дурсгалд зориулан ийнхүү нэрлэжээ.

Уг бүс нэлээд хөгжсөн. 2002-2011 оны хооронд Ла Либертад бүс нутгийн эдийн засгийн өсөлт 7.2 хувь хүрсэн нь Перу Улсын дунджаас өндөр байв. Ийнхүү өссөн нь уул уурхайн үйл ажиллагаанаас (үндсэндээ Баррик Мисквичилка компани) үүдэлтэй байсан. Мөн Ла Либертад бүсэд ХАА-н бүтээгдэхүүний экспортын чиглэлийн компаниуд олноороо үйл ажиллагаа явуулдаг онцлогтой.

Эдийн засгийн идэвхтэй хүн ам (ЭЗИХА):

Перу Улсын хэмжээнд эдийн засгийн идэвхтэй хүн ам нийт хүн амынх нь 74 хувийг эзэлдэг. Ажилгүйдлийн түвшин 4 хувь. Гэхдээ нийт ажиллагсдыг аваад үзвэл дөнгөж 50 хувь нь л үндэсний стандартад нийцсэн хөдөлмөрийн нөхцөлтэй ажил эрхэлдэг хэмээн тооцжээ. ЭЗИХА-ын 44 хувийг эмэгтэйчүүд бүрдүүлдэг. Ажлын байрны 72 хувь нь албан бус байдаг.

Ла Либертад бүсийн хувьд тодорхой тоо мэдээ байхгүй боловч улсын түвшинтэй адил эдийн засгийн үзүүлэлттэй байна гэж үзэн бүсэд ойролцоогоор ийм байгаа гэж таамаглаж болох юм. Энэ нь ч үндэслэлтэй таамаглал юм.

Хөдөлмөр, ажил эрхлэлтийг дэмжих бүсийн удирдах байгууллагын бүрэлдэхүүн:

Бүсийн удирдах байгууллагын Хөдөлмөр, ажил эрхлэлтийг дэмжих багт захирал (эмэгтэй), 7 орон тооны төрийн албан хаагч, 4 богино хугацааны гэрээт ажилтан багтдаг.

Захирлыг Засгийн газраас томилдог. Гурван дэд захирал (бүгд эрэгтэй) шатлан дэвших зарчмаар сонгогддог. Хоёр нарийн бичиг (аль аль нь эмэгтэй), хоёр байцаагчтай (эрэгтэй, эмэгтэй). Богино хугацааны гэрээт ажилтнууд байцаагч, дэд захирлуудад тусалж, заримдаа бичиг хэргийн ажлыг хийдэг. Гурван эмэгтэй, нэг эрэгтэй энэ үүргийг гүйцэтгэдэг.

Жилийн нийт цалингийн сан 57 300¹ ам доллар юм.

Задаргааг нь харвал:

- Захирал: Жилд 12 000 ам доллар;
- Гурван дэд захирал: Тус бүр нь жилд 6 000 ам доллар;
- Эмэгтэй байцаагч: Жилд 4 000 ам доллар;

¹ Бодит бүс, зөвхөн сургалтын зорилгоор ашиглаж буй тоо.

- Эрэгтэй байцаагч: Жилд 5500 ам доллар;
- Гурван богино хугацааны гэрээт ажилтан эмэгтэй: Тус бүр нь жилд 3 000 ам доллар.
- Богино хугацааны гэрээт ажилтан эрэгтэй: Жилд 4 000 ам доллар;
- Хоёр нарийн бичиг: Тус бүр нь жилд 2 400 ам доллар.

Хөдөлмөр, ажил эрхлэлтийг дэмжих бүсийн удирдах байгууллагын үр шим хүртэгчид:

Хөдөлмөр, ажил эрхлэлтийг дэмжих бүсийн удирдах байгууллага гурван үндсэн хөтөлбөртэй. Үүнд:

- Хөдөлмөрлөх эрхийг хамгаалах хөтөлбөр;
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр;
- Зохицуулалтын тогтолцоог сайжруулах хөтөлбөр.

Мэдээж, менежментэд зориулсан нөөц хөрөнгөтэй.

Жишээ болгон Хөдөлмөрлөх эрхийг хамгаалах хөтөлбөрийг харцгаая. Уг хөтөлбөр 2016 (аудит хийсэн жил) онд 600² хүнд үйлчилсний 480 нь эрэгтэй байв. Нийт 60 000 ам долларыг уг үйлчилгээнд зарцуулсан.

Хөтөлбөрийн хүрээнд стандартын шаардлага хангахгүй хөдөлмөрийн нөхцөлийн талаар гомдол гаргаж буй хүмүүст зөвлөгөө, тусламж үзүүлэх, хамгаалах болон ажлын байрны гэнэтийн шалгалт хийх үйлчилгээ үзүүлдэг. Гэвч газар дээр нь шалгалт хийхэд хөрөнгө мөнгө хангалтгүй байсны улмаас 2016 онд хоёр дахь үйлчилгээг огт хийгээгүй.

Канад зөвлөхийн зүгээс өгсөн сөрөг дүгнэлт:

Канадын Засгийн газрын санхүүжилтээр жендэрийн аудит хийх үүрэгтэй Канад зөвлөх ажиглалт судалгаа хийсний үндсэн дээр байгууллага эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хооронд тэгш бүс байдал тогтоход хүргэж буй нөхцөлийг бий болгосон гэж дүгнэсэн.

Зөвлөх яагаад, ямар шалтгааны улмаас ингэж дүгнэсэн гэж та бодож байна вэ?

² Бодит бүс, зөвхөн сургалтын зорилгоор ашиглаж буй тоо.